



“ДЦС-4” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

*[Handwritten signature]*

Ү.ТӨМӨРХУЯГ

“ДЦС-4” ТӨХК-ИЙН УЙЛДВЭРЧНИЙ  
ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ ДАРГА

*[Handwritten signature]*

Д.ГАН-ЭРДЭНЭ

“ДУЛААНЫ ДӨРӨВДҮГЭЭР ЦАХИЛГААН СТАНЦ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ,  
УЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ  
ХООРОНД БАЙГУУЛСАН  
ХАМТЫН ГЭРЭЭ

Энэхүү гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа тул

2024 оны 05 сарын 13 ны өдөр бүртгэв.

БАНТОН ДУУМБЕР
ХӨДӨНДӨР, ХАМГААГАХ
УМЫНДЫН ХАШИЛ Х.ТН.К
Бүртгэл №: 16
Огноо: 2024.05.13
Цаг, минут: 16:03
Бүртгэгч: Б.Армунзорон



БҮРТГЭЛИЙН ДУГААР: 16



**“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ,  
ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ  
ХАМТАРСАН ТУШААЛ/ТОГТООЛ**



2024 оны 05 дугаар сарын 02 -ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар А/203/09

**2024-2025 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн дөрөв дүгээр бүлэг, Үйлдвэрчний Эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.3-т заасныг үндэслэн Компанийн Захиргаа, Үйлдвэрчний Эвлэлийн Хорооны хамтарсан хурлаас ТУШААН/ТОГТООХ нь:

1. 2024-2025 оны Хамтын гэрээг хавсралт ёсоор баталсугай.
2. Хамтын гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн алба (Ш.Туухайнжин), Үйлдвэрчний эвлэлийн хороо (Д.Ган-Эрдэнэ)-нд тус тус үүрэг болгосугай.



“ДЦС-4” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ

У.ТӨМӨРХУЯГ

“ДЦС-4” ТӨХК-ИЙН ҮЙЛДВЭРЧНИЙ  
ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ ДАРГА

Д.ГАН-ЭРДЭНЭ



Захиргаа, ҮЭ-ийн Хорооны 2024 оны ... дугаар сарын 02-ны өдрийн хурлын хамтарсан 1/02/09 тушаал/тогтоолын хавсралт

## “ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК, ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ ХООРОНД БАЙГУУЛСАН 2024-2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХАМТЫН ГЭРЭЭ

2024 оны 05 дугаар сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн дөрөвдүгээр бүлэг, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 1.3, Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, Монгол Улсын Эрчим хүчний салбарын 2023-2024 онд мөрдөх хамт /тариф/-ын хэлэлцээрийг үндэслэн ажил олгогчийг төлөөлж “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргаа, нийт ажилтныг төлөөлж “ДЦС-4” ТӨХК-ийн Үйлдвэрчний эвлэлийн хороо хамтран өмнөх хүрсэн түвшинг дордуулахгүйгээр ажилтнуудын хөдөлмөрийн харилцааг болон хуулиар шууд зохицуулаагүй бусад асуудлыг зохицуулах зорилгоор энэхүү хамтын гэрээг байгуулж байна.

**Гэрээний зорилго нь:** Хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж баталгаажуулах, нийт ажилтны нийгмийн хамгааллын асуудлыг хууль эрх зүйн хүрээнд дэс дараатай шийдвэрлэх, тэдний амьдралын түвшинг байнга дээшлүүлэх, үйлдвэрлэлийн үр ашигтай, тогтвортой ажиллагааг хангахад оршино.

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргаа, Үйлдвэрчний Эвлэлийн Хороо /цаашид ҮЭ-ийн хороо гэх/-ны хооронд хамтын гэрээг байгуулан харьяа дүүргийн нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэн мөрдөж ажиллана.
- 1.2. Компанийн захиргаа нь санхүү, эдийн засгийн чадавхиас хамааран энэхүү гэрээний заалтуудыг чанд биелүүлэх, ҮЭ-ийн хороо нь хамтын гэрээний заалт, тэдгээрийн биелэлтийг хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж, явц, үр дүнг хамтран хэлэлцэж байх.
- 1.3. ҮЭ-ийн хороо нь өөрийн эрхээ Монгол Улсын хуулийн хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд хамтын гэрээтэй холбоотой асуудлаар захиргаатай аль болох гэрээ, хэлэлцээр, зөвшилцлийн замаар шийдвэрлэж байх.
- 1.4. Хамтын гэрээний заалтуудыг биелүүлэх эдийн засгийн үндэс нь ажил олгогчийн санхүүгийн чадавх болох тул компанийн орлого, ашгаа нэмэгдүүлэхэд Эрчим хүчний яам, салбарын агентлагууд, ҮЭ-ийн холбоо, Ажил олгогч эздийн ассоциаци хуулийн хүрээнд бодлого, шийдвэрээрээ дэмжинэ.

- 1.5. Хамтын гэрээ нь тус компанийн нийт ажилтан, ажил олгогч, компанийн ахмадын хороонд бүртгэлтэй ахмадууд, мөн компанид бүртгэлтэй үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах болон ердийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хүнд адил тэгш эрхтэйгээр үйлчилнэ.

## **ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ**

- 2.1. Ажлын байрыг олноор цөөрүүлэх, хөдөлмөрлөх нөхцөл байдлыг дордуулахад хүргэх орон тоо, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийхдээ аж ахуйн нэгж байгууллага /ажил олгогч/ нь нэг сарын өмнө ҮЭ-ийн хороонд урьдчилан мэдэгдэж, ажилтны хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хангах, нийгмийн хамгааллын талаар тусгай гэрээ байгуулж, орон нутгийн хөдөлмөр зохицуулалтын албанд бичгээр мэдэгдэнэ.
- 2.2. Ажил олгогч нь иргэн ба ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг бичгээр 3 хувь байгуулж, хөдөлмөр эрхлүүлэх бөгөөд уг гэрээндээ хамтын гэрээ, хэлэлцээрт заасан нийгмийн баталгаа, нөхцлийг хангахаар тусган тохирно.
- 2.3. Монгол Улсын хуулийн дагуу Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын бүтцийг өөрчлөн зохион байгуулах, хувьчлах тохиолдолд ажилтнууд болон өндөр насны тэтгэвэрт гарсан, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг шинэ бүтцээр зохион байгуулагдан хувьчилж авсан байгууллага хариуцна.
- 2.4. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчин, ердийн болон ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон иргэн, өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг ажил олгогчийн санаачилгаар тэдний мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагыг ашиглах зорилгоор өөрийнх нь эрүүл мэндэд харшлахгүй ажлын байраар хангаж болно.
- 2.5. Компанийн хүний нөөцийн менежментийн бодлоготой уялдуулан үйлдвэрт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтны хүүхдийг мэргэжлийн чиглэлийн дагуу ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлнэ.

## **ГУРАВ. ЦАЛИН ХӨЛС**

- 3.1. Компанийн захиргаа нь өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын улсын индексийг харгалзан цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлж, төрийн өмчийн оролцоотой эрчим хүчний үйлдвэрүүдийн дотор тэргүүлэх түвшинд байлгана.
- 3.2. Компанийн захиргаа нь ажилтнуудынхаа цаг зэргийн тарифт болон албан тушаалын цалинг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 10-аас доошгүй хувиар, 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 15-аас доошгүй хувиар тус тус нэмэгдүүлнэ.
- 3.3. Сахилгын нэг удаагийн зөрчилд сахилгын шийтгэлийн хэлбэрүүдийг давхардуулан ногдуулахгүй байх зарчмаар сарын болон жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг ногдох хувиар олгоно.
- 3.4. Компанийн хэмнэлт болон үйлдвэрлэлийн бус үйл ажиллагаанаас орох орлогын ашгаас ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд зарцуулна.

- 3.5. Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.6 дахин нэмэгдүүлэн тогтоож мөрдөнө. Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өндөр насны тэтгэвэр тогтоолгох, ажилтанд тэтгэмж олгох, нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх, мөнгөн шагнал олгох, дагалдан ажилтны цалинг тогтооход хэрэглэнэ.
- 3.6. Компанийн мэргэжлийн зэрэгтэй ажилтнуудын тарифын итгэлцүүрийг дор дурьдсанаар тогтоож, цалингийн сүлжил, жишгийг гүйцэтгэх захирлын тушаалаар баталж, мөрдөнө. Үүнд:

Тарифын	Мэргэжлийн зэрэг					
	I	II	III	IV	V	VI
Итгэлцүүр	1.0	1.11	1.38	1.54	1.72	1.92

№	Байгууллага	Үйл ажиллагааны чиглэл	Нөхцөл	
			Хэвийн	Хэвийн бус
1	"ДЦС-4" ТӨХК, "ЦДҮС" ТӨХК, "УБЦТС" ТӨХК, "УБДС" ТӨХК, "ДҮТ" ТӨХХК, "ДЦС-3" ТӨХК	Ашиглалт	2.6	2.75
		Засвар	2.4	2.6
2	"БНЗӨБЦТС" ТӨХК, "Да-Сэ ЦТС" ХК, "Дарханы ДЦС" ТӨХК, "Эрдэнэтийн ДЦС" ТӨХК, "ДЦС-2" ТӨХК, "ДБЭХС" ТӨХК, "Эрдэнэт- Булганы ЦТС" ТӨХК, "ӨБЦТС" ТӨХК, Эрчим хүчний барилга угсралтын компаниуд	Ашиглалт	2.2	2.4
		Засвар	1.9	2.2
3	Бусад ДЦС болон ДС, цахилгаан түгээх сүлжээ, дамжуулах сүлжээ, дулааны шугам сүлжээ	Ашиглалт	2.1	2.3
		Засвар	1.9	2.1
4	Аймаг орон нутгийн эрчим хүчний (дизель ба сэргээгдэх эрчим хүчний систем, байгууллага)	Ашиглалт	2.0	2.2
		Засвар	1.8	2.0

### 3.7. Нэмэгдэл хөлс олгох талаар

- 3.7.1. Гүйцэтгэх захирлын тушаалаар ажилтныг ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх хэлбэрээр ажиллуулахдаа нэмэгдэл хөлсийг хослон, түр орлон, хавсран ажилласан албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгоно. /Ээлжийн амралттайгаас бусад үед ажлын 10-аас дээш хоног ажиллах бол/
- 3.7.2. Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэгдэл ажил, үүргийг гүйцэтгэвэл ажил олгогч ажилтантай тохиролцон нэмэгдэл хөлсийг 40 хүртэл хувиар тооцон олгоно.
- 3.7.3. Тасралтгүй ажиллагаатай ажлын байранд ээлжээр ажилладаг ажилтнууд болон үйлдвэрлэлийн хэвийн найдвартай ажиллагааг хангахаар ээлжийн бус

ажилтныг графикайн дагуу шөнийн цагаар ажиллуулсан тохиолдолд шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг дундаж цалин хөлснөөс 35 хувиар бодож олгоно.

- 3.7.4. Үйлдвэрлэлийн хэвийн найдвартай ажиллагааг хангахаар ажилтныг шөнийн цагаар дуудаж ажиллуулсан тохиолдолд шөнийн цагийг 1.2 дахин нэмэгдүүлж нөхөн амраана. Ажилтныг ажлын зайлшгүй шаардлагаар нөхөн амруулаагүй бол 3.7.3-т заасны дагуу цалин хөлсийг нэмэгдүүлэн олгоно.
- 3.7.5. Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж мэргэшлийн өндөр ур чадвар гаргаж байгаа ажилтанд ур чадварын нэмэгдэл олгож болох бөгөөд энэ нь үндсэн цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэнэ. Ур чадварын нэмэгдэл олгох журмыг гүйцэтгэх захирлын тушаалаар баталж мөрдөнө.
- 3.7.6. Монгол Улсын зөвлөх инженерт албан тушаалын үндсэн цалингийн 20 хувьтай, Монгол Улсын мэргэшсэн ажилтанд үндсэн цалингийн 15 хувьтай тэнцэх хэмжээний хүртэл нэмэгдэл урамшууллыг бүтээлийн тайлан, үр дүнг үндэслэн журмаар зохицуулан олгоно.
- 3.7.7. Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг олгохдоо тухайн ажилтны сүүлийн 3 сарын дундаж цалин хөлсөөр тооцно. Дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд сарын үндсэн цалин, ажилласан жилийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, нөхцөлийн нэмэгдэл, сарын үр дүнгийн нэмэгдлийг тооцно.

### 3.8. Нэмэгдэл олгох талаар

- 3.8.1. “ДЦС-4” ТӨХК-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтнуудад ажилласан жилийн нэмэгдлийг хүснэгтэд заасны дагуу хувийг тогтооно. Эрчим хүчний салбарын бүтцийн өөрчлөлтөөр, дээд байгууллагын шийдвэрээр салбартаа шилжин ажиллаад эргэж ирсэн болон хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгоод эдгэрч, эргэж ажилдаа орсон тохиолдолд ажилтныг “ДЦС-4” ТӨХК-д ажилласанд тооцно. Компанид өмнө нь ажилласан жил, “ДЦС-4” ТӨХК-д хөлсөөр ажиллах гэрээгээр ажилласан хугацаа, эрчим хүчний бусад байгууллагад ажилласан жилийг журмын дагуу тооцно. Үүнд:

д/д	Ажилласан жил	Үүнд	
		Хэвийн бус	Хэвийн
1	2-оос 4 хүртэл	15	10
2	4-өөс 7 хүртэл	25	20
3	7-оос 10 хүртэл	30	25
4	10-аас 15 хүртэл	35	30
5	15 ба түүнээс дээш жил	40	35

Тайлбар: 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2 жилийн босгыг 1.5 жилээр тооцно.

- 3.8.2. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтны цагийн тарифт цалинг хэвийн нөхцөлд ажилладаг ажилтны цагийн тарифт цалингаас 12 хувиар дээгүүр тогтооно.

3.8.3. Эрдмийн зэрэгтэй ажилтанд албан тушаалын үндсэн цалингаас доорх нэмэгдлийг гүйцэтгэх захирлын тушаалаар олгоно.

-Шинжлэх ухааны докторын зэрэгтэй 15% (Sc.D)

-Докторын зэрэгтэй 10% (Ph.D)

3.8.4. Ариун цэврийн өрөө "00" цэвэрлэдэг ажилчин, физик эмчилгээний эмч, мах шулагч, шат бэхэлгээний мастер, шат бэхэлгээний засварчин, шат бэхэлгээний гагнуурчин нарт сарын үндсэн цалингаас тооцож 12%-ийн нэмэгдэл олгоно.

3.8.5. 1А, 1Б категоритой гагнуурчдад сарын үндсэн цалингаас тооцож 30 хувь хүртэл нэмэгдэл олгоно.

### **3.9. Олговор олгох талаар**

3.9.1. Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлэх боломжгүй бол уг ажилтны үндсэн цалингийн 60%-иар тооцож олговор олгоно.

3.9.2. Хүүхэд асрах чөлөө дууссан, эсхүл дуусаагүй боловч ажилдаа орсон ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын тооцооны дагуу мөнгөн олговор олгоно.

3.9.3. Ажилтан ажил олгогчийн шийдвэрээр долоо хоногийн амралтын өдөр болон нийтээр амрах баярын өдрүүдэд ажиллахаар хүлээсэн бол тухайн хугацаанд ногдох үндсэн болон тарифт цалингийн 30%-ийн олговрыг олгоно.

### **3.10. Цалин хөлс олгох хугацааны талаар**

3.10.1. Ажилтны цалин хөлсийг сар бүрийн 10, 20, 30-ны өдрүүдэд олгоно. Хэрэв цалин хөлсийг олгохоор тогтоосон өдрүүдэд амралт болон баяр ёслолын өдөр тохиовол урд өдөр нь олгоно.

3.10.2. Ажилтны хүсэлтээр цалин хөлсийг нь урьдчилан олгож болно.

### **3.11. Үйлдвэрлэлийн үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсний талаар**

3.11.1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны сарын үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсийг албан тушаалын ба үндсэн цалингийн сангийн 50 хувиар нэгж бүрээр төлөвлөж түүнийг олгох журмыг гүйцэтгэх захирлын тушаалаар баталж мөрдөнө. Хувь хүнд сарын үйлдвэрлэлийн үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсний дээд хэмжээг үндсэн цалингаас хэтрүүлж болохгүй.

3.11.2. Ажилтнуудад жилийн ажлын үр дүнг харгалзан 3-5 хүртэл сарын албан тушаалын ба тарифт гүйцэтгэлийн цалингийн дундаж хэмжээний нэмэгдэл хөлс олгоно. Нэмэгдэл хөлсний хэмжээг ТУЗ-өөр батлуулна. Нэмэгдэл хөлс олгох журмыг гүйцэтгэх захирлын тушаалаар баталж мөрдөнө.

3.11.3. Ажилтанд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны алдагдлыг бууруулсан, норм нормативыг хэмнэсэн нөхцөлд хэмнэлтийн сангаас 30 хүртэл хувиар урамшуулал олгож болох бөгөөд жил, сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсөнд үл хамаарна.

3.11.4. Үндсэн ажлынхаа гадуур өмч хамгаалахад нэмэгдэл ажил үүргийг гүйцэтгэж зүтгэлтэй ажиллаж, алдагдсан хөрөнгийг олж илрүүлэхэд тусалсан тус

компанийн болон гэрээт байгууллагын ажилтан, иргэдэд мөнгөн урамшуулал олгож болно.

- 3.11.5. Оновчтой санал, төсөл хэрэгжүүлэх замаар зардал хэмнэсэн тохиолдолд бодит хэмнэлтийн 20 хүртэлх хувийг олгож болох бөгөөд холбогдох журмын дагуу шийдвэрлэнэ.

### **ДӨРӨВ. ЭЭЛЖИЙН АМРАЛТЫН ЗОХИЦУУЛАЛТ**

- 4.1. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласан хугацаанд ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан үндсэн амралт дээр нь дор дурьдсан нэмэгдэл амралтыг олгоно.

- 1 дэх жилийн эхнээс 4 дэх жилийг дуустал ажлын 5 өдөр;
- 5 дахь жилийн эхнээс 6 дахь жилийг дуустал ажлын 7 өдөр;
- 7 дахь жилийн эхнээс 10 дахь жилийг дуустал ажлын 9 өдөр;
- 11 дэх жилийн эхнээс 15 дахь жилийг дуустал ажлын 10 өдөр;
- 16 дахь жилийн эхнээс 20 дэх жилийг дуустал ажлын 11 өдөр;
- 21 дахь жилийн эхнээс 25 дахь жилийг дуустал ажлын 12 өдөр;
- 26 дахь жилийн эхнээс 31 дэх жилийг дуустал ажлын 15 өдөр;
- 32 дахь жилээс дээш жилд ажлын 18 өдөр.

Энэхүү нэмэгдэл амралт олгох албан тушаалын жагсаалтыг гүйцэтгэх захирал батална.

- 4.2. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдлэж чадаагүй ажилтанд ээлжийн амралтын цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгох бөгөөд гүйцэтгэх захирлын тушаалаар дараа оны эхний сарын 10-ны өдрийн дотор шийдвэрлэнэ.
- 4.3. Ажил олгогч нь бүх ажилтныг тухайн жилдээ багтаан ээлжийн амралтаа хэсэгчлэн болон бүтнээр нь биеэр эдлэх бололцоогоор хангаж ажиллана.

### **ТАВ. АЖИЛТНУУДЫН МЭРГЭЖИЛ, БОЛОВСРОЛ**

- 5.1. Ажилтнуудын ажлын байрны сургалтыг тусгай хөтөлбөрийн үндсэн дээр зохион байгуулж, гарын авлага, компьютер, бусад техник хэрэгслээр хангана.
- 5.2. Хүний нөөцийн бодлогын хүрээнд зохион байгуулалттай сургалтаар техник технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг эзэмшүүлэх зорилгоор ажилтныг компанийн зардлаар гадаад, дотоодын их дээд сургууль, коллежид болон бусад түргэвчилсэн сургалтанд гэрээгээр суралцуулж болно.
- 5.3. Ажилтнуудын эрхэлж байгаа ажлын онцлогтой уялдуулж тэдний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх чиглэлийн сургалтанд, ижил төстэй гадаадын болон дотоодын байгууллагад туршлага судлуулах зорилгоор сургаж болно.
- 5.4. Ажлын байран дээр сургалт зохион байгуулж, хичээл заасан багш нарт олгох хөлсийг батлагдсан төлөвлөгөөнд багтаан хэлцлийн журмаар тогтооно.
- 5.5. Ажлын байранд IV ба түүнээс дээш зэргээр ажилтныг хугацаанд нь дагалдуулан сургасан багш нарт ажлын байранд сургалт хийсэн нэмэгдэл



- хөлсийг 400,000 хүртэл төгрөгөөр тооцож батлагдсан төлөвлөгөөнд тусгасны дагуу олгоно.
- 5.6. Нарийн мэргэжил эзэмших ажилтныг дагалдуулан сургах багш нарыг гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
  - 5.7. Эрчим хүчний салбарын хэмжээнд ажил мэргэжлийн уралдаан, тэмцээнд зохион байгуулалттай оролцож ажлын арга барил, шинэ туршлага, мэдээ мэдээллийг солилцоно.
  - 5.8. Шинэ ажилтны үндсэн цалинг түүний гүйцэтгэх ажил үүрэг, эзэмших ажлын дадлага, ур чадвар зэргийг өөртэй нь тохиролцож тогтоох бөгөөд ижил төрлийн ажил үүрэг гүйцэтгэж байгаа үндсэн ажилтны үндсэн цалингийн 80-аас дээш хувиар тогтооно. Мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан ажлын байранд ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа талууд харилцан тохиролцож албан тушаалын болон тарифт цалинг тогтооно.
  - 5.9. Ажлын байр өөрчлөгдөж байгаа ажилтанд ажлын дадлага, ур чадвар эзэмшүүлэх зорилгоор дадлага, туршлагатай ажилтныг дагалдуулан ажиллуулахдаа ажилтны үндсэн цалинг дагалдуулан сургах хөтөлбөрт заасан мэргэжлийн зэргийн цалингийн 80-аас дээш хувиар тогтооно. Тухайн цалингийн 80% нь эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрээгүй тохиолдолд эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтооно./
  - 5.10. Тус компанид ажиллаж байгаа ажилтан ажлын шаардлагаар мэргэжил солихоор дагалдан ажиллах хугацаанд өөрчлөгдсөн албан тушаалын ба мэргэжлийн зэргийн тарифт цалин, ажилласан жилийн нэмэгдэл, сар, жилийн ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг 6 сарын хугацаанд тухайн албан тушаалд хөдөлмөрийн гэрээ байгуулж шалгалт өгч тэнцэх хүртэл олгоно.
  - 5.11. Мэргэжил дээшлүүлэх сургалт, компанийн зардлаар гадаад улс оронд болон өөрийн оронд суралцахаар чөлөөлөгдсөн ажилтанд 3 хүртэлх сарын хугацаанд нь үндсэн цалинг олгоно. Гадаад болон дотоодод 3 сараас дээш хугацаагаар суралцаж буй ажилтны ар гэрт нь үндсэн цалингийн 70%-ийн хэмжээнд тэтгэмж олгох асуудлыг гүйцэтгэх захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсний үндсэн дээр гүйцэтгэх захирал тушаал гаргана.
  - 5.12. Инженер техникийн ажилтан үндсэн ажил мэргэжлийн чиглэлээр аспирантур, докторантур, гадаад, дотоодын их дээд сургуульд магистрантурт суралцаж цаашид тогтвор суурьшилтай, идэвх санаачилгатай бүтээлчээр ажиллах нөхцөлтэйгээр сургалтын гэрээ байгуулж, гэрээг үндэслэн сургалтын төлбөрийг төлж болно.

### **ЗУРГАА. АЖИЛ, АМРАЛТЫН ГОРИМ ТОГТООХ**

- 6.1. Компанийн ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цаг, долоо хоногийн ажлын цаг нь 40 байна.
- 6.2. Ээлжийн бус ажилтнуудын ажлын өдөр 8 цагт эхэлж, 17 цагт дуусах бөгөөд амрах, хооллох үеийн завсарлага эхлэх, дуусах цагийг Хөдөлмөрийн дотоод журмаар тогтооно.
- 6.3. Ээлжийн ажлын үргэлжлэх хугацаа 12 цагаас илүүгүй байна.

- 6.4. 12 цагийн үргэлжлэлтэй ээлжийн ажилтнууд өглөө 8 цагаас оройн 20 цаг хүртэл, оройн 20 цагаас өглөөний 8 цаг хүртэл, 8 цагийн үргэлжлэлтэй ажилтнууд өглөөний 8 цагаас 16 цаг, оройн 16 цагаас шөнийн 24 цаг хүртэл, шөнийн 0 цагаас өглөөний 8 цаг хүртэл тус тус ажиллана.
- 6.5. Ажилтнуудыг 3 ээлжээр ажиллуулах тохиолдолд шалтгаан болон хугацааг тодорхой заасан графикийг ҮЭ-ийн хороонд мэдэгдэж, "ДЦС-4" ТӨХК-ийн ерөнхий инженерээр батлуулан мөрдөж ажиллана.
- 6.6. Ээлжийн ажилтнуудыг хоёр ээлжинд дараалан ажиллуулж болохгүй.
- 6.7. Үйлдвэрлэлийн хэвийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангахаар ажилтныг ажлын тогтоосон өдрийн цагийг хэтрүүлэн илүү цагаар болон нийтээр амрах баярын ба долоо хоногийн амралтын өдөр ажиллуулж болох бөгөөд илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол нэмэгдэл хөлсийг энэхүү хамтын гэрээнд зааснаар олгоно. Захиргаа дараах чиглэлийг баримталж ажиллана.
  - 6.7.1. Ажилтныг илүү цагаар /даалгаврын хуудсаар/ ажиллуулах долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 16 цагаас илүүгүй байна. Долоо хоногт ажиллуулах илүү цагийн дээд хэмжээ хуанлийн ажлын цагийн 40%-иас хэтэрч үл болно.
- 6.8. Станцад гарсан аваари устгах ажлыг зохион байгуулах, компанийн тайлан, мэдээ гаргах, төлөвлөгөө, төсөл зохиох зэрэг цаг алдалгүй яаралтай ажил гүйцэтгэх, гэрээ хэлэлцээр байгуулахаар ажилтныг ажлын өдрийн тогтоосон цагийг хэтрүүлэн илүү цагаар болон нийтээр амрах баярын ба долоо хоногийн амралтын өдөр ажиллуулах асуудлыг компанийн гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ. Уг ажилтныг нөхөн амруулаагүй бол илүү цаг ажилласны хөлсийг олгохдоо гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 6.9. Ургийг 6 сараас дээш хугацаанд тээж байгаа /жирэмсэн/ ажилтны ажлын цагийг эрүүл мэндийн байдал, эмнэлгийн тодорхойлолтыг үндэслэн 2 цагаар хорогдуулж болно. Хорогдуулсан цагийг ажилласнаар тооцно.

### **ДОЛОО. ЧӨЛӨӨ ОЛГОЛТ**

- 7.1. Ажилтанд өөрийнх нь хүсэлтээр тухайн нэгжийн удирдах ажилтны тодорхойлолтыг үндэслэн шалтгаан, нөхцөл байдлыг ЗХНА судалж танилцуулснаар гүйцэтгэх захирал чөлөө олгох, чөлөөтэй байх хугацаанд олговор олгох эсэхийг шийдвэрлэнэ. Олговрыг үндсэн цалингаас тооцож олгоно.

### **НАЙМ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ХОХИРЛЫГ НӨХӨН ТӨЛӨХ**

- 8.1. Мэргэжлийн байгууллага /Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс/-аас үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан нь тогтоогдсон ажилтанд, нас барсан ажилтны ар гэрт хууль тогтоомжид заасан хэмжээгээр нөхөн төлбөрийг олгоно.
- 8.2. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан ажилтны ар гэрт, мөн хөдөлмөрийн чадвараа алдсан нь тогтоогдсон ажилтанд эрүүл мэнд, амьдралын зайлшгүй шаардлагыг харгалзан өргөдлийг

нь судалж үзсэний үндсэн дээр нөхөн төлбөрийг нэг ба түүнээс дээш удаа гүйцэтгэх захирлын тушаалаар олгож болно.

- 8.3. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтанд анхны тусламж үзүүлж, шаардлагатай эм тариа бусад эмнэлгийн хэрэгслээр хангах болон анхан шатны баримтыг үндэслэн эмнэлгийн зардлыг 100% компани хариуцна. Дээрх шалтгаанаас үүдэлтэй яаралтай мэс засал хийлгэх шаардлага гарвал нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн эмчилгээний зардлыг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж гүйцэтгэх захирлын тушаалаар баталгаажуулан нэг удаа олгоно.
- 8.4. Амьжиргааны өртөг өөрчлөгдсөнтэй холбогдуулан нөхөн төлбөрийн хэмжээг Засгийн газрын тогтоолыг үндэслэн индексжүүлж олгоно.

### ЕС. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

- 9.1. Компанийн "Хөдөлмөрийн аварга"-ыг Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 4 дахин нэмэгдүүлсэн, шалгарсан ажил, онцгой бүтээлийн тусгай шагнал болон ажил мэргэжлийн аваргыг 3 дахин нэмэгдүүлсэн, компанийн хүндэт дэвтэрт бичигдсэн ажилтныг 3 дахин нэмэгдүүлсэн төгрөгөөр тус тус шагнана. Компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан журмыг мөрдөнө.
- 9.2. Хөдөлмөрийн амжилт гаргасан тэргүүний ажилтны зургийг хүндэт самбарт алдаршуулан 500,000 /таван зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагнал олгоно.
- 9.3. Хөдөлмөрийн амжилт гаргасан тэргүүний ажилтныг дараах зэргийн мөнгөн шагналаар шагнана. Үүнд:
  - Нэгдүгээр зэрэг 350,000 төгрөг
  - Хоёрдугаар зэрэг 300,000 төгрөг
  - Гуравдугаар зэрэг 260,000 төгрөг
- 9.4. "ДЦС-4" ТӨХК-ийн Хүндэт ажилтан тэмдгээр шинээр шагнагдсан ажилтанд нэг удаа 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгийн мөнгөн урамшуулал олгоно.
- 9.5. Компанийн ажилтан эрхэлсэн ажил хөдөлмөртөө өндөр амжилт гаргаж Монгол Улсын Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн баатар цолоор шагнагдвал салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн шагналаар, Төрийн соёрхолт болон Гавьяат цолоор шагнагдвал салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 15 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн шагналаар, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнагдвал 1,500,000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагналаар, Алтан гадас одонгоор шагнагдвал 1,000,000 /нэг сая/ төгрөгийн мөнгөн шагналаар, Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдвал 500,000 /таван зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагналаар, Засгийн газрын шагнал салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдвал 150,000 /нэг зуун тавин мянга/ төгрөгийн мөнгөн шагналаар, Жуух бичгээр шагнагдвал 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагналаар, Монголын залуучуудын холбооны шагналаар шагнагдвал 50,000 /тавин мянга/ төгрөгийн мөнгөн шагналаар тус тус нэг удаа шагнана. /Тэтгэвэр тогтоолгосон ахмад настан болон үйлдвэрийн осол,

- мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хүнд нэгэн адил хамаарна./
- 9.6. Гүйцэтгэх захирлын тушаалаар Монгол Улсын Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн баатарт 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн, Гавьяат ажилтанд 20,000 /хорин мянга/ төгрөгийн, Засгийн газрын шагнал Эрчим хүчний тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнуулсан ажилтанд 15,000 /арван таван/ төгрөгийн, бусад салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдгээр шагнуулсан ажилтанд 10,000 /арван мянган/ төгрөгийн урамшууллыг сар бүр олгох бөгөөд жилд 2 удаа нэгтгэн олгоно. Компанид ажиллаж байсан ахмадууд, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хүмүүст нэгэн адил хамаарагдана. Хөдөлмөрийн баатарт олгох урамшууллыг Захиргаа, ҮЭ-ийн хороо тэнцүү хувааж гаргана.
  - 9.7. Олимп, дэлхийн аварга, Монгол Улсын Төрийн наадамд түрүүлж ерөнхийлөгчийн зарлигаар цол хүртсэн ажилтныг нэг удаа 10,000,000 /арван сая/ төгрөгийн мөнгөн шагналаар, Монгол Улсын болон байгууллагын нэрийн өмнөөс олон улс, улсын чанартай биеийн тамир, урлаг, уран сайхан, ажил мэргэжлийн тэмцээн, уралдаанд оролцож онцгой амжилт гаргасан ажилтныг, компанийн ахмадын хороонд бүртгэлтэй ахмадыг, компанид ажиллаж байгаад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хүнийг компанийн зэргийн мөнгөн шагналаар шагнана.
  - 9.8. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан, ажил төрлийн талаар хамтын ажиллагаатай ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтнуудыг 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж болно.
  - 9.9. Компанид үр бүтээл идэвх санаачлагатай ажиллаж байгаа ажилтанд анх гэр бүл болоход тус компанид хоёулаа ажилладаг бол 500,000 /таван зуун мянга/ төгрөгийн, ганцаараа ажилладаг бол 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгийн урамшууллыг нэг удаа олгоно. Захиргаа, ҮЭ-ийн хороо урамшуулалд зарцуулагдах зардлыг хувь тэнцүү гаргана.
  - 9.10. Өвлийн ачаалал давсан, зуны их засварын ажлын бүтээмж, үр ашгийг харгалзан зун, намрын цагт жилдээ 48-аас доошгүй ажилтныг эх орны үзэсгэлэнт газраар болон гадаад оронд аялуулна. /Байгалийн болон гэнэтийн давагдашгүй хүчин зүйл тохиолдсон, улс орон даяар нийтийг хамарсан халдварт өвчин тархсантай холбоотой эрх бүхий байгууллагаас хорио цээрийн дэглэм тогтоосноос бусад үед аялуулна/ Захиргаа, ҮЭ-ийн хороо хамтран зохион байгуулж зарцуулагдах зардлыг хувь тэнцүү гаргана.
  - 9.11. Эрчим хүчний салбарын чиглэлээр орон нутагт албан ажлаар /урилгаар/ тус компаниас ажилтан ажиллаж ажил үүргийг богино хугацаанд чанартай гүйцэтгэсэн тухай ажиллуулагч байгууллагын тодорхойлолтыг үндэслэн компанийн зэргийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.
  - 9.12. Эрчим хүчний ажилтны өдөр болон компанийн тэмдэглэлт ойг тохиолдуулан нийт ажилтнуудыг шагнаж урамшуулах асуудлыг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

## **АРАВ. АЖИЛТАНД ХӨНГӨЛӨЛТ ЭДЛҮҮЛЭХ**

- 10.1. Ажилтан магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд 14 хүртэл хоног сувилуулахад нэг хоногийн байр, хоолны зардлыг 60,000 /жаран мянга/ төгрөгөөр тооцож жилд нэг удаа ҮЭ-ийн хороо 40%-иар, Захиргаа 40%-иар хөнгөлнө. Тэтгэвэрт байгаа ахмадууд, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хүмүүст захиргааны 40% хөнгөлөлт олгоно.
- 10.2. Ажилтнуудын хоолны үнийг 60 хувиар хөнгөлнө. /Графикт бус илүү цагаар ажиллаж байгаа ажилтны ажилласан хугацааг тооцоололд нэмэлтээр оруулж хөнгөлнө./
- 10.3. "ДЦС-4" ТӨХК-ийн ажилтнуудыг ажилдаа ирэх, ажлаас тарахад нь батлагдсан маршрутын дагуу тусгай унаагаар үйлчилнэ.
- 10.4. Хэсэгчилсэн зогсолт, гэнэтийн аваар саатлын үед ажилласан ажилтны хоолны үнийг Захиргаа хариуцна.
- 10.5. Халаалтын улирлын хөнгөлөлтийг зөвхөн гэр хороололд амьдардаг ажилтан, өндөр настны тэтгэвэрт гарсан ахмадууд, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хүмүүст 100,000 /нэг зуун мянга/ төгрөгөөр бодож олгоно. Орон сууц болон орон сууцны дэмжлэг авсан хүнд хамаарахгүй. Гэр бүлийн зөвхөн 1 гишүүнд олгоно.

## **АРВАН НЭГ. БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ**

- 11.1. Компанийн ажилтан нас барсан тохиолдолд ар гэрт нь эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх, ажилтны эхнэр, нөхөр, төрсөн эцэг, эх, хүүхэд нь нас барж уй гашуу тохиолдоход эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр буцалтгүй тусламж олгоно. /Гэр бүлээрээ болон ах дүү, хэд хэдэн хүн тус компанид ажилладаг бол зөвхөн нэг хүнд нь олгоно./
- 11.2. Тус компанийн харьяалал бүхий өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон иргэн нас барвал ар гэрт нь эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн, тэдний эхнэр, нөхөр, төрсөн эцэг, эх, хүүхэд нь нас барсан тохиолдолд эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгийн буцалтгүй тусламж олгоно. /Гэр бүлээрээ болон ах дүү, хэд хэдэн хүн тус компанид ажилладаг бол зөвхөн нэг хүнд нь олгоно./
- 11.3. Хувийн өргөдлийг үндэслэн ар гэрт нь зайлшгүй мөнгөн тусламж үзүүлэх шаардлагатай бол тухайн байгууллагын бүртгэлд байгаа өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадууд, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон иргэн, өрх толгойлсон эх, эцэг, бүтэн өнчин үлдсэн айлын нэг хүүхдэд ам бүлийн өндөр настан, насанд хүрээгүй болон хөдөлмөрийн чадваргүй хүмүүсийг оролцуулаад нэг хүнд ногдох орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээнд хүрэхгүй байгаа нөхцөлд харьяа хороо, захиргаа, үндсэн нэгжийн тодорхойлолтоор нэг удаа эрчим хүчний салбарын

- хэмжээг тухайн байгууллагад ажилласан жилээр үржүүлж нэг удаа тэтгэмж олгоно.
- 12.4. "ДЦС-4" ТӨХК-нд сүүлийн таван жил тасралтгүй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарах эрх нь үүссэн ажилтан тэтгэвэр тогтоолгохоос өмнө нас барсан тохиолдолд 12.2-д заасан тэтгэмжийн зардлын 50 хувийг гэр бүлд нь олгоно.
  - 12.5. Тус компанийн харьяалалд байдаг өндөр настан, ҮО, МШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон станцад ажилладаггүй хүнд сар бүр 5,000 /таван мянга/ төгрөгийн тэтгэмжийг олгоно.
  - 12.6. Компанийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах, чадвартай боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор ажилтан бүрт орон сууц худалдан авахад нь зориулж нэг удаа 20,000,000 /хорин сая/ төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тухайн жилд 50-иас дээш хүнд үзүүлнэ. Санхүүгийн дэмжлэгийг Захиргаа хариуцан гаргана.
  - 12.7. Архи, тамхинаас үүдэлтэй өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, түүний хор хөнөөлтэй тэмцэх талаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан нэгж, хамт олон, ажилтанд компанийн Захиргаа, ҮЭ-ийн хороо дэмжлэг үзүүлнэ.
  - 12.8. Хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалт, соёл амралтын төв, сувилал, үйлчилгээний байгууллагаар хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэхэд ҮЭ-ийн хороо дэмжинэ.
  - 12.9. Төрийн холбогдох шагналд нэр дэвшигчдийг МҮЭ-ийн холбоогоор дэмжүүлэхэд ҮЭ-ийн хороо тусалцаа үзүүлнэ.
  - 12.10. Ажилтан хорт хавдар, хүнд хэлбэрийн цус харвалт, мэс засалд орсон тохиолдолд эмчийн зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн эмчилгээний зардлын зохих хувийг нэг удаа захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу гаргаж болно.
  - 12.11. Эрчим хүчний салбарт бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр ажлын байрыг цөөрүүлэх, орон тоог цомхотгох, хувьчлагдах тохиолдолд ажлаас халагдсан ажилтны нийгмийн баталгааг хангах зорилгоор өмчийн хэлбэр үл харгалзан уг ажилтанд тус салбарт 1-4 жил ажилласан бол 4 сар, 5-10 жил ажилласан бол 6 сар, 11-15 жил ажилласан бол 12 сар, 16 ба түүнээс дээш жил ажилласан бол 24 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгоно.
  - 12.12. Ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдвол компанид 6 сараас 2 хүртэл жил ажилласан бол 2 сарын, 2 жилээс 5 хүртэл жил ажилласан бол 3 сарын, 5 жилээс 10 хүртэл жил ажилласан бол 4 сарын, 10 ба түүнээс дээш жил ажилласан бол 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгоно.
  - 12.13. 3 хүртэлх насны хүүхдээ асрах чөлөөтэй байгаа ажилтанд /эх эсхүл эцэг/ жил тутамд эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр мөнгөн тэтгэмж олгоно. Хүүхэд асрах чөлөө олгох тушаал гарснаас хойш 12 сарын хугацааг нэг жилээр тооцно.

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний буцалтгүй тусламж үзүүлж болно.

- 11.4. Байгалийн болон гэнэтийн аюул /газар хөдлөлт, гал, үер ус, онц аюултай цасан ба шороон шуурга/ гамшигт өртөж хохирсон өрхөд хохирлын хэмжээг тооцон эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5 хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн тусламж үзүүлнэ. Тусламжийн хэмжээг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргана.
- 11.5. Ажиллаж байгаа ажилтан тасралтгүй 2 сараас дээш хугацаагаар өвчилсөн тохиолдолд эмнэлгийн магадлагааг үндэслэн эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн тусламж үзүүлнэ. Тусламжийг Захиргаа хариуцаж гаргана.
- 11.6. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ахмадууд өвчний улмаас мэс засалд орсон, удаан хугацаагаар эмчилгээтэй байгаа тохиолдолд хувийн өргөдөл, ахмадын хорооны тодорхойлолт, эмнэлэгийн магадлагааг үндэслэн жилд нэг удаа 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгийн буцалтгүй тусламжийг 20 хүртэл хүнд үзүүлж болно.
- 11.7. Ургийг 6 сараас дээш хугацаанд тээж байгаа /жирэмсэн/ ажилтанд эмнэлгийн тодорхойлолтыг үндэслэн эрүүл мэндийг нь дэмжиж нэг удаа 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгийг ҮЭ-ийн хорооноос олгоно.

#### **АРВАН ХОЁР. ТЭТГЭМЖ, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ**

- 12.1. “ДЦС-4” ТӨХК-д 20 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа ажилтанд 50, 60 насны ойг тохиолдуулан тэдэнд эрхэлж байгаа албан тушаалын нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгоно. Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хүнд, мөн дээрх болзлыг хангасан өндөр настанд 50, 60, 70, 80, 90, 100 насны ойгоор нь 60,000-110,000 төгрөгийн тэтгэмжийг олгоно. Үүнд: 50 нас-60,000 төгрөг, 60 нас-70,000 төгрөг, 70 нас-80,000 төгрөг, 80 нас-90,000 төгрөг, 90 нас-100,000 төгрөг, 100 нас-110,000 төгрөгөөр тооцно.
  - 12.1.1. 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хүнд, мөн дээрх болзлыг хангасан өндөр настанд 50, 60, 70, 80, 90, 100 насны ойгоор нь 100,000-1,000,000 төгрөгийн тэтгэмжийг олгоно. Үүнд:
    - 50 нас-100,000 төгрөг, 60 нас-150,000 төгрөг, 70 нас-200,000 төгрөг, 80 нас-300,000 төгрөг, 90 нас-500,000 төгрөг, 100 нас-1,000,000 төгрөгөөр тооцно.
- 12.2. “ДЦС-4” ТӨХК-д сүүлийн 5 жил тасралтгүй ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа ажилтанд тухайн салбарт ажилласан бүх сарыг оролцуулан жил тутамд эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр бодож нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгоно.
- 12.3. Тус компанид ажиллаж байгаад ҮО, МШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон хүн өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тохиолдолд эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод

## **АРВАН ГУРАВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ**

- 13.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд байгууллагын үйлдвэрлэл үйлчилгээний жилийн зардлын 1.5%-иас доошгүй хэмжээний хөрөнгийг зарцуулна.
- 13.2. Ажлын байрны нөхцөл сайжруулах, үйлдвэрлэлийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр болзолт уралдаан зарлаж, үлгэр жишээ ажлын байр, осол зөрчилгүй ажилласан хамт олныг шалгаруулж байна.
- 13.3. Ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, эрүүл мэндэд хор нөлөөлөлгүй, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангана.
- 13.4. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг турших, худалдаж авах, хадгалах, угааж цэвэрлэх, засварлах, ариутгах зардлыг ажил олгогч хариуцна.
- 13.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хүрээнд үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, ажлын байрны нөхцлийг тодорхойлох чиглэлээр стандартын дагуу хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэж сайжруулах арга хэмжээ авч зөвлөмжийн дагуу нөлөөллийг багасгаж ажиллана.
- 13.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах төлөвлөгөөг боловсруулж ажиллахын зэрэгцээ олон нийтийн бусад байгууллагатай хамтарч ажиллана.
- 13.7. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтныг хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүнээр хангана.
- 13.8. Ажил олгогч нь ажилтныг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу үйлдвэрлэл, ажил үйлчилгээтэй холбоотой зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хугацаат үзлэгт заавал оруулна.
- 13.9. Компанийн эмнэлэгт шаардлагатай яаралтай тусламжийн эм тариа, бүх төрлийн материал, тоног төхөөрөмжийн төлбөрийг компани хариуцахаас гадна үйлдвэрлэлийн байранд 24 цагаар эмнэлгийн тасралтгүй үйлчилгээг явуулна.
- 13.10. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд 12 жил 6 сараас дээш жил ажилласан 50-иас дээш насны эмэгтэйчүүд, 55-аас дээш насны эрэгтэйчүүдийн ажил үүргийн онцлог, төвөгшил, ажлын байрны шаардлагыг харгалзан тэдний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор эрхэлж байсан ажил албан тушаалын цалин хөлсийг бууруулахгүйгээр тохирох ажлын байранд ажил олгогч ажилтныг хүсвэл ажиллуулж болно.
- 13.11. ХАБЭА-н сарын аяныг жил бүрийн 4 дүгээр сард зохион байгуулах бөгөөд 28-ны өдрийг үйлдвэрлэлийн ослоор амь эрсэдсэн хүмүүсийн гэгээн дурсгалыг хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулна.



## АРВАН ДӨРӨВ. ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ЭРХИЙГ ХАНГАХ

- 14.1. ҮЭ-ийн хороо нь эрх, үүргээ Монгол улсын хуулийн хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд асуудлыг аль болох хэлэлцээр /зөвшилцөл/-ийн замаар шийдвэрлэж байна.
- 14.2. Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хуульд заасан эрх, баталгааг хангахын зэрэгцээ компани нь;
  - 14.2.1. Компанийн захирлын зөвлөлд ажилтнуудын хөдөлмөр эрхлэлт, ажлын байр, бүтэц зохион байгуулалт, хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлсний асуудал зэргийг хэлэлцэхэд ҮЭ-ийн хорооны даргыг зөвлөх эрхтэйгээр оролцуулна.
  - 14.2.2. ҮЭ-ийн хороог ажиллах нөхцлөөр хангахад туслалцаа үзүүлэн гишүүдийн татварыг бүх гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн сарын цалин хөлснөөс нэг хувиар тооцон бэлэн бусаар хурааж, ҮЭ-ийн хорооны дансанд сар бүрийн 5-ны дотор шилжүүлнэ. /Хууль тогтоомжид нийцүүлэн цалин хөлснөөс хийх суутгалыг хувь хүний зөвшөөрөл, хүсэлтийг бүрдүүлэх асуудлыг Захиргаа, ҮЭ-ийн хороо хамтдаа шийдвэрлэнэ./
  - 14.2.3. Компанийн ажилтнуудын хөдөлмөрлөх эрхтэй холбоотой журмыг боловсруулахад ҮЭ-ийн хорооны саналыг авна.
- 14.3. ҮЭ-ийн хороо нь хуулийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна.
  - 14.3.1. Хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах, батлах, явц, үр дүнг хэлэлцэх;
  - 14.3.2. ҮЭ-ийн гишүүд, идэвхтэн, сонгуультны дунд хичээл, сургалт, семинар, зөвлөгөөн, туршлага судлах зэрэг ажлуудыг зохион байгуулах;
  - 14.3.3. Ажилтнаас ҮЭ-ийн хороонд ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хэлэлцэх;
  - 14.3.4. ҮЭ-ийн хорооны тэргүүлэгчдийн хурал хийх;
  - 14.3.5. ҮЭ-ийн хорооны бүх гишүүдийн хурлыг жил бүрийн 4 дүгээр сард багтаан хийх;
  - 14.3.6. Ажил олгогчтой тохиролцсоны дагуу зохион байгуулах бусад арга хэмжээнүүд;
- 14.4. Үйлдвэрчний эвлэлийн орон тооны сонгуульт ажилтныг хамтын гэрээнд хамруулан сарын болон жилийн ажлын үр дүнгийн нэмэгдэл хөлс, цол, ажилласан жил, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг Захиргаа олгоно.
- 14.5. Олон жил идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа ажилтнуудыг төр засгийн шагналд компанийн холбогдох журмын дагуу ажил олгогчтой зөвшилцөн тодорхойлж болно.
- 14.6. Эрчим хүчний салбарын хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор цахилгаан, дулааны үнэ тарифыг нэмэгдүүлэхэд салбарын ҮЭ-ийн холбоо, ҮЭ-ийн хороо дэмжлэг үзүүлж ажиллана.

## АРВАН ТАВ. ГЭРЭЭГ БИЕЛҮҮЛЭХ

- 15.1. Гэрээний биелэлтийн явцыг жилд 2 удаа талууд төлөөлөгчдийн хамтарсан хурлаар хэлэлцэж холбогдох арга хэмжээг авч ажиллана.

- 15.2. Гэрээгээр хүлээсэн үүрэг зөрчигдсөн тохиолдолд аль нэг тал маргаантай асуудлыг шийдвэрлэхийн тулд төлөөлөгчдийн хуралдааныг 7 хоногийн дотор зарлан хуралдуулах эрхтэй. Нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 15.3. Гэрээний талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 15.4. Хамтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн маргааныг Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 15.5. Хамтын гэрээ нь талуудын гарын үсэг зурж, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаанд хүчинтэй. Гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас өмнө шинэ гэрээ байгуулаагүй, эсхүл нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол талууд энэхүү гэрээг үргэлжлүүлэн мөрдөнө.
- 15.6. Удирдлагын бүтэц бүрэлдэхүүн, өмчлөлийн харьяалалд өөрчлөлт орох нь энэхүү хамтын гэрээгээр тохирсон асуудлыг цуцлах үндэслэл болохгүй.

**АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
 Ү.ТЕМЕРХУЯГ  
 ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ  
 ДАРГА  
 Ш.ТУУХАЙНЖИН  
 ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДАРГА  
 Ж.ЭНХЦОГТ  
 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЛБАНЫ ДАРГА  
 Б.БАТЗОРИГ  
 БОРЛУУЛАЛТ МАРКЕТИНГИЙН АЛБАНЫ  
 ДАРГА  
 Б.ОЮУНЦАЦРАЛ  
 ТӨЛӨВЛӨЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН  
 ХЭЛТСИЙН ДАРГА  
 Ц.ӨСӨХНЭМЭХ  
 САНХҮҮ БҮРТГӨЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
 Б.ЦЭНДЭЭ  
 ТҮЛШ ДАМЖУУЛАХ ЦЕХИЙН ДАРГА  
 П.БАЯР-ЭРДЭНЭ  
 ЗУУХАН ЦЕХИЙН ДАРГА  
 Л.ГАНБОЛД  
 ТӨЛӨВЛӨЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН  
 ХЭЛТСИЙН АХЛАХ ЭДИЙН ЗАСАГЧ  
 Ч.АЛТАНГЭРЭЛ  
 ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ  
 ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН АХЛАХ  
 МЭРГЭЖИЛТЭН  
 Ю.ЭНХЭЭ

**ҮЭ-ИЙН ХОРООГ ТӨЛӨӨЛЖ:**

ҮЭ-ИЙН ХОРООНЫ ДАРГА  
 Д.ГАН-ЭРДЭНЭ  
 ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ  
 И.АРИУНБОЛД  
 ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ  
 Э. ГАНЗОРИГ  
 ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ  
 Э.ГҮРЖАВ  
 ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ  
 Б.НАРМАНДАХ  
 ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ  
 Д.ЦЭРЭНХҮҮ  
 ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ  
 Ж.ЧОЙЖИН-ОДСЭР  
 ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ  
 Ц.ХАСМӨРӨН  
 ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ  
 Б.САЙНБАЯР  
 ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ  
 С.ПҮРЭВСҮРЭН  
 ҮЭ-ИЙН ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧ  
 Д.ЭНХЗУЛ